



МОНГОЛ УЛС
БАЯНХОНГОР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2021 оны 10 сарын 27 өдөр

Дугаар А/660

Номгон

Аж ахуйн нэгжийн тооллого явуулах
аймаг, сумын комисс байгуулах тухай

Статистикийн тухай хуулийн 18 дугаар зүйлийн 1 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 315 дугаар тогтоолын 3 дахь хэсэг, 2021 оны аймгийн Хөгжлийн төлөвлөгөөний 45 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аж ахуйн нэгжийн 2021 оны ээлжит тооллогыг 2021 оны 11 дүгээр сарын 01-30 ний өдрүүдэд аймгийн хэмжээнд зохион байгуулж явуулах аймгийн тооллогын комиссын бүрэлдэхүүнийг нэгдүгээр, сумын комиссын бүрэлдэхүүнийг хоёрдугаар, комиссын ажиллах удирдамжийг гуравдугаар хавсралтаар тус тус баталсугай.


2. Эдийн засгийн суурь болсон Аж ахуйн нэгжийн тооллогын ажилд өндөр ач холбогдол өгч сум, багийн түвшинд бэлтгэл, зохион байгуулалтыг сайтар хангуулан мөрдөж буй аргачлал, заавар журмын дагуу чанартай зохион байгуулж, аж ахуйн нэгж байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгч бүрийг тооллогод бүрэн хамруулж ажиллахыг комисс (Б.Батсуурь)-т үүрэг болгосугай.

3. Аж ахуйн нэгжийн тооллогыг цахимаар явуулж 2021 оны 11 дүгээр сарын 30-ны дотор Статистикийн хэлтэст баталгаажуулан хүлээлгэн өгөхийг сумдын Засаг дарга, аж ахуйн нэгжийн тооллогын ажлыг аргачлал, маягт, заавраар бүрэн хангаж ажиллахыг Статистикийн хэлтэс (Х.Ганзориг)-т тус тус даалгасугай.

4. Тооллогын зорилго ач холбогдлыг аж ахуйн нэгж, байгууллага, иргэдэд таниулан сурталчлах ажлыг хэвлэл мэдээллийн алба (Д.Дэлгэрсайхан)-д үүрэг болгосугай.

5. Аж ахуйн нэгжийн тооллогын ажилд зарцуулахаар 2021 оны аймгийн хөгжлийн төлөвлөгөөнд тусгагдсан 6.0 (зургаан сая) төгрөгийг санхүүжүүлэхийг Санхүү, төрийн сангийн хэлтэс (С.Байгалмаа)-т зөвшөөрсүгэй.

6. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Б.Батсуурь)-д даалгасугай.

ДАРГА  Д.МӨНХСАЙХАН

60110545

Аймгийн Засаг даргын 2021 оны 19 дугаар
сарын 27 ны өдрийн 1162 захирамжийн
01 дүгээр хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГО ЯВУУЛАХ
АЙМГИЙН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга: Б.Батсуурь (Засаг даргын орлогч)
Орлогч дарга: Х.Ганзориг (Статистикийн хэлтсийн дарга)
Гишүүд: С.Байгалмаа (Санхүүгийн хэлтсийн дарга)
С.Рэнцэндагва (Татварын хэлтсийн дарга)
Ц.Мөнхжаргал (Улсын бүртгэлийн хэлтсийн
Дарга)
Т.Хишигбаатар (Хөрөнгө оруулалт, хөгжлийн
бодлого төлөвлөлтийн хэлтсийн дарга)
Б.Оюутболд (Цагдаагийн газрын дарга)
Ж.Мөнхсоёл (Баянхонгор сумын Засаг дарга)
Г.Энхтүвшин (Худалдаа аж үйлдвэрийн
танхимын тэргүүн)
Ш.Гэрэлсүх (Санхүү, төрийн сангийн
хэлтсийн бүртгэлийн мэргэжилтэн)
Нарийн бичгийн дарга: Х.Оюунчимэг (Статистикийн хэлтсийн ахлах
Мэргэжилтэн)

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар
сарын 27-ны өдрийн 466 Захирамжийн
02 дугаар хавсралт

АЖ АХУЙН НЭГЖИЙН ТООЛЛОГО ЯВУУЛАХ
СУМДЫН КОМИССЫН БҮРЭЛДЭХҮҮН

Комиссын дарга:	Сумын засаг дарга
Гишүүд:	Санхүү албаны дарга
	Татварын байцаагч
	Улсын бүртгэгч
	Баянхонгор сумын Хөрөнгө оруулалт, хөгжлийн бодлого хариуцсан мэргэжилтэн
	Баянхонгор сумын Үйлдвэрлэл, үйлчилгээ хариуцсан мэргэжилтэн
	Төсөвт байгууллагын дарга, эрхлэгч, нягтлан бодогч нар
	Багийн засаг дарга
Нарийн бичгийн дарга:	Статистикийн асуудал хариуцсан ажилтан

_____ооо_____

Аймгийн Засаг даргын 2021 оны 10 дугаар
сарын 27-ны өдрийн А/660 захирамжийн
03 дугаар хавсралт

КОМИССЫН АЖИЛЛАХ ЖУРАМ

Аймаг, нийслэлийн тооллогын комисс нь холбогдох асуудлаар харьяа сум, дүүргийн комиссын ажлын уялдаа холбоог удирдлага, арга зүйгээр хангаж ажиллана

Аж ахуйн нэгж, байгууллага, хувиараа хөдөлмөр эрхлэгчд (ХХЭ)-ийн хүрээг тогтоох, тооллогод хамруулах төлөвлөгөөг батлуулах, тоолох үед тооллогод өдөрт хамрагдах нэгжийн бүрэн хамруулахад хяналт тавих, тооллогын явцыг мэдээлэх, сурталчлах зэрэг ажлыг хийнэ.

Тоолох үе болон тоолох үе шатны ажлын дараа онлайн материал болон сумдаас цаасаар ирсэн тооллогын материалыг шалгаж хүлээн авах, нэгтгэх, тайлан, илтгэх хуудсыг хэлэлцэж баталгаажуулах болон тооллогын материалыг хадгалах ажлыг зохион байгуулна.

Комиссын гишүүдтэй холбоо барих утас, гэрийн хаяг бүхий лавлагааны материал бэлтгэнэ.

Тооллогын үед ААНБ, ХХЭ-ээс мэдээлэл цуглуулах явцад гарсан хүндрэл, бэрхшээлийг шийдвэрлэж ажиллана. Өөрсдөө шийдвэрлэх боломжгүй тохиолдолд дээд шатны комисст мэдэгдэж холбогдох арга хэмжээг авна. Шийдвэрлэх боломжгүй хүндрэл бэрхшээлийг ҮСХ-нд мэдэгдэнэ.

Тоологч/шалгагч нарыг www.toollogo.1212.mn (цаашид онлайн програм гэх) бүртгэлжүүлж, үнэмлэх олгох, чиг үүргийг биелүүлэхэд хяналт тавьж ажиллана.

-Тоологч/шалгагч нь ААНБ, ХХЭ-ийн мэдээллийн нууцлалыг хуулийн дагуу чандлан хадгалах үүрэгтэй. Тооллогын материалыг хүлээн авч, эмхлэн хадгалах, баримтжуулалт хийж, орон нутгийн тооллогын комисст хүлээлгэн өгч ажиллана.

-Тоологч/шалгагч нь өөрийн аюулгүй байдалд анхаарч, аюулгүй ажиллагааны дүрмийг баримталж ажиллана. Хүндрэл бэрхшээл тулгарвал цаг алдалгүй тухайн шатны тооллогын комисст хандаж, асуудлыг шийдвэрлүүлнэ.

-Тоологч/шалгагч нь тооллогын сургалтанд бүрэн хамрагдаж, идэвхтэй оролцож, асуулгын хуудсыг бүрэн зөв, зааврын дагуу асууж, нөхөх үүрэгтэй. Тооллогын материалыг хүлээн авч, эмхлэн хадгалах, баримтжуулалт хийж орон нутгийн тооллогын комисст хүлээлгэн өгч ажиллана.

-Тоологч/ шалгагч нь ААНБ, ХХЭ-ийн мэдээллийн нууцлалыг хангаж ажиллах үүрэгтэй.

Тооллогын Комиссын гишүүдийг сургалтад бүрэн хамруулахад анхаарч, холбогдох сургалтын тоног төхөөрөмжийн бэлэн байдлыг хангаж ажиллана.

Тооллогын нөхөгдсөн асуулга, бусад материал шалгаж хүлээн авах, ҮСХ-нд хүлээлгэн өгнө.

Тооллогын Комиссын гишүүд, тоологч/шалгагчийг тооллогын үед үндсэн ажлаас нь түр чөлөөлж, ажиллах бололцоогоор хангах талаар аймаг, нийслэл, сум, дүүргийн комисс арга хэмжээ авч, зохицуулалт хийнэ.

_____ооо_____